Z үеийнхний онцлогт тулгуурласан сувилахуйн боловсролын шинэлэг хандлага

Э.Мөнгөнтуул[1], Д.Баттогтох[1], Б.Буяндэлгэр[1]

[1]АШУҮИС. Сувилахуйн сургууль
Цахим хаяг: munguntuul@mnums.edu.mn, Утас: 95026442

Түлхүүр үг:

Z үе
Сувилахуйн боловсрол
Цахим сургалт
Технологийн хөгжил

Товч утга: Сүүлийн жилүүдэд цар тахлаас (COVID 19) үүдэлтэй хөл хорио, хязгаарлалтуудын улмаас манай орны дээд боловсролын салбарт танхимын сургалтыг цахим хэлбэрээр явуулах зайлшгүй шаардлага бий болсон билээ. Цахим сургалтыг хэрэгжүүлэх явцад онолын мэдлэг олгож буй багш нарт шинэ үеийн буюу Z үеийн суралцагчидтай харилцахад зарим талаар бэрхшээл учирч байсан. Тиймээс бид шинэ (Z) үеийнхний онцлог шинжүүд, тэдэнд сувилахуйн боловсролын хүрээн дэх онолын мэдлэг олгох заах арга зүйн шинэлэг хандлагуудыг судлах зорилго дэвшүүлсэн юм. Энэ хүрээнд нэгдүгээрт: Z үеийнхэн гэж хэн бэ? гэдэгт тоймлон хариулах, хоёрдугаарт: Z үеийнхэнд илүү тохиромжтой заах аргын хувилбаруудыг тодруулах зорилтуудыг тавилаа. Судалгааны үр дүнгээс үзэхэд, Z үеийнхэн нь технологийн мэдлэг чадвар, итгэл үнэмшил, зан үйлийн өвөрмөц хослолоороо өмнөх үеийн оюутнуудаас ихээхэн ялгаатай юм. Энэхүү онцлог шинжүүд нь сургалтыг уламжлалт хэлбэрээр хөтлөн явуулах нь хангалтгүй байгааг илтгэн харуулж байна. Тиймээс сувилахуйн боловсролд Z үеийнхэнд чиглэсэн заах арга зүйг үндэсний онцлогтой уялдуулан боловсруулах, багш нарын технологитой ажиллах чадварыг дээшлүүлэх, техник тоног төхөөрөмжийн шинэчлэлт хийх шаардлага тавигдаж байгаа юм.

Үндэслэл: Нийгэм, эдийн засгийн байдал хурдацтай хөгжин тэлэхийн хэрээр их сургуульд элсэн суралцах оюутнуудын нас, туршлага төдийгүй төрөлх чадвар өөрчлөгдөж байгааг боловсрол судлаач нар эрдэм шинжилгээний бүтээлүүддээ онцолж байна.[1-3] Шинээр элссэн суралцагчдын шинж төрх, өвөрмөц онцлогийг багш, сурган хүмүүжүүлэгчид танин мэдсэнээр хичээлийг амжилттай хөтлөн явуулах, дэвшүүлж буй зорилтондоо хүрэх, мэдлэг, чадвартай мэргэжилтэн бэлтгэн гаргах зэрэг олон талын ач холбогдолтой.[4-5] Иймээс сувилахуйн боловсролын хүрээнд Z үеийн суралцагчдад чиглэсэн сургалтын арга барил, хэрэглүүрүүд шинэчлэгдэж байгааг бид анзаарахгүй өнгөрөхийн аргагүй юм.[6]

Судалгааны материал, арга зүй: Сувилахуйн боловсролын өөрчлөлт шинэчлэлтийн талаар судалсан олон улсын судлаачдын өгүүлэл, ном бүтээлүүд болон сувилахуйн чиглэлээр суралцагсдын тоон статистик, сургалтын практикт тулгарч байгаа асуудлуудад дүн шинжилгээ хийж, танин мэдэхүйн логик (анализ, синтез, индукц, дедукц, харьцуулан жишилтийн г.м) аргууд болон контент анализын аргыг ашигласан.

Үр дүн: Хүний насны ангиллыг үндсэн онцлогуудаар нь үечлэн X, Y, Z үе гэсэн томъёоллыг олон улсад түгээмэл ашиглаж байгаа бөгөөд эдгээр үеүд нь хоорондоо олон талаар ялгаатай байдаг.[7-8] Насны ангиллын хувьд Монгол Улсын нийт хүн амын 18.3% нь 1995-2010 оны хооронд төрсөн Z үеийнхэн байгаа боловч манай орны өвөрмөц технологийн нэвтрэлтээс шалтгаалаад тухайн насны ангилалд багтаж байгаа бүх иргэдийг шууд Z үеийн онцлогт хамааруулж болохгүй гэдгийг анхаарах нь зүйтэй.[9] Учир нь амьжиргааны түвшин, хот болон орон нутгийн ялгаанаас хамаарч Z үеийн онцлогийг харьцангуй цөөн хувь нь илэрхийлж байж болох юм. Гэвч эдүгээ сувилахуйн чиглэлээр суралцагчдын гол цөмийг Z үеийнхэн бүрдүүлж байгаа билээ.

Z үеийн оюутнууд олон жилийн туршид боловсрол, дадлагад нөлөөлөх хандлага, итгэл үнэмшил, нийгмийн хэм хэмжээ, зан үйлийн өвөрмөц хослолтой байдаг.[10] Тиймээс сувилахуйн боловсрол эзэмшихээр суралцаж буй Z үед хамаарах оюутнууд унших дадлыг хэрхэн эзэмшсэн, хэрхэн бодож, юунд анхаарч, санаа тавьдаг, хэрхэн харилцахыг илүүд үздэгийг ойлгосон байх ёстой болж байна.[8] Өмнө өгүүлсэн мэдээ баримтаар сувилахуйн чиглэлээр элсэгчид нь үе үеийн төлөөлөл байх боломжтой боловч дийлэнх оюутнууд насны хувьд нэг үеийнх байдаг учраас тухайн давамгайлж буй үеийнхний онцлогийг судлан таних нь сургалтын үйл явцыг амжилттай хэрэгжүүлэхэд тус дөхөм болно. Тэгэхээр сувилахуйн чиглэлээр суралцаж буй оюутнуудад онолын суурь мэдлэгийг олгохын тулд суралцагчдынхаа үе хоорондын онцлогийг илүү сайн ойлгох нь сургалтыг үр дүнтэй явуулах, удирдан чиглүүлэхэд ихээхэн чухал.[11]

Судалгаанаас үзэхэд, Z үеийнхний гол онцлог нь технологийг байнга ашигладаг тул нийгмийн болон харилцааны чадвар сул байх хандлагатай байдаг. Энэ нь цаашлаад сэтгэлийн түгшүүр, сэтгэлийн хямрал зэргээр сэтгэцийн эрүүл мэндийн асуудалд өртөх эрсдэлтэй дагуулдаг.[12] Мөн эдүгээ бид сувилахуйн ерөнхий болон суурь шинжлэх ухаануудын хичээлийг онолын мэдлэгийн хэлбэрээр ном, сурах бичигт агуулагдаж буй мэдээлэлд суурилсан арга зүйг түлхүү ашиглаж байгаа нь энэ чиглэлээр суралцаж байгаа Z үеийнхний хэрэгцээ шаардлагыг хангаж, онцлогт тэр бүр нийцэж чадахгүй байдал ажиглагддаг. Гэтэл Z үеийн оюутнууд өдөрт 30 минутаас илүү хугацааг уншихад зарцуулахыг хүсдэггүй бөгөөд урт бичвэрүүдийг уншихаас богино хэмжээний материалыг уншихыг эрмэлздэг байна.[13] Сургалтын арга хэлбэр жил ирэх тусам шинэчлэгдэж байгаа боловч онолын мэдлэг эзэмшүүлэх хичээлүүд оюутнуудад унших материал их өгч, хичээлийн үзүүлэн нь бичвэрт суурилсан (power point) хэвээрээ бөгөөд ихэвчлэн олон хувилбарт сорилоор мэдлэгийг шалгаж байна. Гэтэл суралцагчдын ихээхэн хувийг эзлэж байгаа Z үеийн онцлог, шинж чанарыг харгалзан үзвэл дээрх аргуудаа бүхэлд нь үргэлжлүүлэн хэрэглэх нь оновчтой бус бөгөөд суралцагчдын хэрэгцээнд нийцүүлэхэд бэрхшээл учирч болох юм. Улмаар нийгмийн идэвхитэй харилцаанд оролцох сонирхол хомс байдаг нь хичээл сургалтын явцад тодорхой нөхцөлд бэрхшээл учруулж байдаг.

Тиймээс онолын мэдлэг олгох хичээлүүдийн арга зүй, ашиглах хэрэглүүрийн цар хүрээг улам бүр өргөжүүлэн Z үеийнхнийг дэмжихэд чиглэгдсэн байдлаар баяжуулан ашиглах, цаашдаа бүхэлдээ шинэ хандлагад шилжин орохыг цаг үе шаардаж байна. Энэ хүрээнд технологийн дэвшил ашигласан анхаарал татахуйц байх, бичвэр мэдээллийг график дүрслэл, зургаар орлуулах, судалгааг дүрслэл (эможи) хэлбэрээр авах зэрэг шинэ арга барилуудыг туршиж үзэх нь оновчтой юм.[4]

Технологийн өндөр түвшний хэрэглэгчид байхаас гадна зарим талаар даамжраад дижитал ертөнцөд гүнзгий автсан байх нь Z үеийнхний нэг гол онцлог нь учраас дижитал эх сурвалжуудын найдвартай байдал, хамаарал, үнэн зөв байдлыг үнэлэх, хэрхэн зөв судалж, иш татах талаар зааварчилгаа өгөх, нөхцөл байдал, нийгмийн сүлжээний хэрэглээтэй холбоотой ёс зүйн хариуцлагын талаар тайлбарлаж өгөх нь сургалтын салшгүй нэгэн хэсэг нь болж байна.[4] Мөн хичээлд видео бичлэг, цахим болон аудио сурах бичиг ашиглах явдал чухал. Сургалтыг зөвхөн танхимын болон цахим байдлаар зохион байгуулахаас гадна хамгийн өргөн хүртээмжтэй технологийн платформуудад суурилсан фэйсбүүк групп, онцлох тэмдэг (hashtag) ашигласан твиттер, багш нарын бүтээсэн YouTube суваг, даалгаврын хугацааг сануулах программ зэргийг үр дүнтэйгээр хэрэглэх шаардлага тавигдаж байна. Гэвч энэ бүхэн нь түгээмэл хэрэгжихийн тулд оюутнуудыг хичээлийн үйл ажиллагаанд оролцохдоо өөрсдийн ухаалаг төхөөрөмжийг ашиглах, сүлжээнд холбогдох нөхцлийг бүрдүүлэхэд хүргэх учраас материаллаг нөөцийн судалгаа, бодит боломжийг сайтар судлах нь чухал. Манай орны сувилахуйн боловсролын хүрээнд эхний ээлжинд оюутнуудын зохих шаардлагыг хангасан хэсэгт уг хандлагыг ашиглан хосломол байдлаар сургалтыг явуулах боломжийг эрэлхийлэх нь оновчтой байж болох юм.

Прагматик хандлага Z үеийнхний төрөлх чанарын нэг болж хөгжсөн учраас онолын сургалтыг явуулахдаа бодит туршлагаас суралцах, агуулгыг амьдралтай холбож тайлбарлах, боломжтой нөхцөлд дадлага хийлгэх зэрэг арга барилуудыг ямагт ашиглах нь зүйтэй.[14] Нийгмийн харилцааны чадвар сул хөгжсөн байдлыг залруулахын тулд суралцагчдыг сонирхолтой байдлаар хэлэлцүүлэгт оролцуулах, идэвхтэй сонсох, бүтээлч шүүмжлэл өрнүүлэх, бусдын үзэл бодлыг хүндэтгэх харилцааны чадварыг тайлбарлаж, хичээлийн явцаар хэрэгжүүлэн дадлагажуулах, оюутнуудад харилцан яриа өрнүүлэхэд нь туслах, даалгаврыг хугацаанд нь үр дүнтэй хийлгэхийн тулд хялбаршуулсан, дөхүүлсэн, дуурайсан хэлбэрүүдийг ашиглахаас гадна өөрт нь шууд хамааралтай агуулгаар баяжуулж өгөх нь онолын мэдлэгийг оновчтой эзэмшүүлэхэд дөхөмтэй.[5,15]

Зөвхөн хичээлийн агуулгын хүрээнд мэдлэг, чадвар эзэмшүүлэхээс гадна суралцагсдын нийгэмшлийн хэрэгцээг хангах асуудалд анхаарлаа хандуулж Z үеийнхний өөрийгөө тусгаарлах, түгших, өөртөө итгэлгүй болох, сэтгэлийн хямралд орох эрсдэл ихтэй онцлогуудыг анхаарч оюутнуудаа тайван, чөлөөтэйгээр хичээлдээ оролцох нөхцлийг хангах, эрүүл хооллолт, гадуур гарах, ангид болон гэрийн нөхцөлд бусадтай биечлэн харилцах, онлайн цагаа хязгаарлах зэрэг эрүүл зан үйлийг хөхүүлэн дэмжих нь өнөөгийн онолын багш нарын бас нэгэн чиг үүрэг болох хандлагатай байгааг тэмдэглэх нь зүйтэй.[4]

Сувилахуйн боловсролын хүрээн дэх онолын суурь мэдлэгийг Z үеийнхэнд олгох шинэлэг хандлагыг амьдралд хэрэгжүүлэхэд заавал хөндөгдөх нэг үндсэн чиглэл нь багшийн хөгжил, технологийн шинэчлэлтийн түвшин юм. Гэвч тус асуудал нь бие даасан судалгааны үр дүнг шаардах учраас бидний судалгаанд төдийлөн хөндөлгүй орхиж байгаа билээ.

Дүгнэлт:

1. Сувилахуйн боловсролын хүрээнд суралцагчдын шинэ үе буюу Z үеийнхэн хүчтэй түрэн орж ирж байгаа учраас онолын суурь мэдлэгийг олгох үйл явцад шинэлэг хандлагыг анхааран үзэх зайлшгүй шаардлагатай байна.
2. Z үеийнхэн сурах арга барил, сэтгэл зүйн онцлог нь өвөрмөц, технологийн чадвараараа өндөр түвшинд хүрсэн учраас сургалтын арга, хэлбэртээ тухайн чиглэлээр шинэчлэлт, ахиц дэвшил гаргахгүйгээр сувилахуйн боловсролын үр дүнг дээшлүүлэхэд цаашид бэрхшээл учирч болзошгүй юм.

Ном зүй:

1. *Cheryl A. Williams. (2018). Nurse Educators Meet Your New Students: Generation Z. Nurse Educator. Vol. 44. No. 2. 59–60.*
2. *Hamdoni K. Pangandaman, Ritchel P. Boloron, Joy Hope C. Lambayong, Mona Liza G. Ergas, Romanoff M. Raki-in, Sittie Ainah M. Mai-Alauya, Jonaid M. Sadang, Ashley A. Bangcola, Paulo Carl G. Mejia, Nursidar P. Mukattil. Innovative classroom pedagogy in nursing education: a systematic review. International Journal of Health Medicine and Current Research. Vol. 4. Issue 04. 1543-1549.*
3. *M. Flores Vizcaya-Moreno, Rosa M. Pérez-Cañaveras. (2020). Social Media Used and Teaching Methods Preferred by Generation Z Students in the Nursing Clinical Learning Environment: A Cross-Sectional Research Study. International Journal of Environmental Research and Public Health., 17 (21). 8267.*
4. *Jennifer Chicca, Teresa Shellenbarger. (2018). Connecting with Generation Z: Approaches in Nursing Education. Teaching and Learning in Nursing. Vol. 13. 180-184.*
5. *Seemiller C., Grace, M. (2016). Generation Z goes to college. San Francisco, CA: Jossey Bass.*
6. *Debbie C. Hampton, Yolanda Keys. (2016). Generation Z students: Will they change our nursing classrooms? Journal of Nursing Education and Practice. Vol. 7. No. 4. 111-115.*
7. *Meet generation z: Forget everything you learned about millennials. (2014). Lifestyle, Marketing, Education.*
8. *Stillman D., Stillman, J. (2017). Gen Z work: How the next generation is transforming the workplace. New York, NY: Harper Collins.*
9. *https://www.1212.mn/tables.aspx?TBL_ID=DT_NSO_0300_003V1*
10. *Igel C., Urquhart, V. (2012). Generation Z, meet cooperative learning. Middle School Journal, 43 (4). 16–21.*
11. *Shatto B, Erwin K. (2016). Moving on from Millennial: preparing for Generation Z. Journal of Continuing Education in Nursing. 47 (6). 253-254.*
12. *Rickes P.S. (2016). Generation in flux: How Gen Z will continue to transform higher education space. Planning for Higher Education Journal, 44 (4). 21–45.*
13. *Seemiller C, Grace M. (2017). Generation Z: educating and engaging the next generation of students. About Campus. 22 (3). 21-26.*
14. *Wiedmer T. (2015). Generations do differ: Best practices in leading Traditionalists, Boomers, and Generations X, Y, and Z. Delta Kappa Gamma, 82 (1). 51–58.*
15. *Merriam S.B., Bierema L.L. (2014). Adult learning: Linking theory and practice. San Francisco, CA: Jossey-Bass.*

Innovative Approaches to Nursing Education Based on the Characteristics of the Z Generation

Munguntuul E[1], Battogtokh D[1], Buyandelger B[1]

[1]Nursing School. MNUMS.
Email: munguntuul@mnums.edu.mn, Tel: 95026442

In recent years, due to the quarantine and restrictions caused by the pandemic (COVID 19), there is an urgent need for online learning in the higher education of our country. During the implementation of online learning, teachers had some difficulties in communicating with Z-generation students. Therefore, we aim to study the characteristics of the new (Z) generation and innovative approaches to provide knowledge in the field of nursing education.

According to the studies the Generation Z different from previous generation in its unique combination of technical knowledge, beliefs, and behaviors. These features suggest that traditional training is not sufficient. Therefore, there is a need to develop teaching methods for Z-generation nursing in accordance with national specifics, to improve teachers' ability to work with technology, and to upgrade technical equipment.

Finally, the educators need to understand generation's transmission and to be flexible for the teaching process and attitude. Regards to characteristics and values of Generation Z, to concern how to best motivate, engage and educate for nursing education.

Key word: Z generation, nursing education, online learning, development of technology